



Монголын Усан Спорт  
Сонирхогчдын Холбоо

# ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН журам

2023 ОНЫ 08 САРЫН 16-НЫ  
ӨДРӨЭС ХҮЧИН ТӨГӨЛДӨР  
ҮЙЛЧИЛНЭ



## МУССХ-НЫ ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ЖУРАМ

### НЭГ. Ёс зүйн зөвлөл, түүний зорилго, үүрэг

- 1.1 Ёс зүйн зөвлөл нь (цаашид Зөвлөл гэх) Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбооны (цаашид Холбоо гэх) дүрмийн 13.4 зүйлд заасан Удирдах зөвлөлийн дэргэдэх зөвлөл юм.
- 1.2 Зөвлөл нь бие даасан хуулийн этгээд биш бөгөөд Холбооны болон Зөвлөлийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.
- 1.3 Ёс зүйн зөвлөлийн зорилго нь:
- а) Холбооны бүхий л үйл ажиллагаа болон арга хэмжээнд ёс зүйтэй зан үйл, харилцааг хэвшүүлэх, спортын эв нэгдлийг хангаж олон нийтийн дунд нэр хүнд нь унахаас сэргийлэх, шийдвэр гаргалтын шударга байдлыг хангуулах
  - б) Бүх төрлийн шударга бүс өрсөлдөөн, хууран мэхлэлт, авлига, ёс зүйн зөрчил болон Холбооны дүрэм болон Ёс зүйн дүрмийг зөрчсөн аливаа үйлдэл/эс үйлдлийн эсрэг тэмцэх
  - в) Холбоо болон түүний гишүүд, тамирчид, дасгалжуулагчид, албаны хүмүүс зэрэг усан спортын үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцогч бүх этгээдүүдэд Холбооны дүрэм болон Ёс зүйн дүрмийг сурталчилан таниулах, мөрдүүлэх
- 1.4 Ёс зүйн зөвлөл нь өөрийн бүхий л нөөц боломжид тулгуурлан Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй зөрчлийг шалган шийдвэрлэхийн тулд доорхи үүргийг хүлээнэ. Үүнд:
- а) Гуравдагч этгээдээс ирүүлж болох болзошгүй ёс зүйн зөрчлийн мэдээллийг хүлээн авах сувгийг бий болгох (утасны дугаар, цахим хаяг г.м)
  - б) Холбогдох байгууллага, хувь хүнээс ёс зүйн зөрчлийн шалгалтанд шаардлагатай мэдээллийг авах, мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн клуб, дасгалжуулагч болон дээд шатны удирдлагаар дамжуулан баталгаажуулах
  - в) Холбооны дүрэм болон Ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх үүрэг бүхий холбооны бүх гишүүд, албан тушаалтан, ажилтнууд, тамирчид, тамирчдыг туслан дэмжигчид болон бусад усан спортод хамаарал бүхий хүмүүст ёс зүйн асуудлаар сургалт, сурталчилгаа явуулах, ёс зүйн дүрмийн биелэлтэнд хяналт тавих
  - г) Хууль тогтоомж болон Ёс зүйн дүрмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, мэдээлэл солилцох, хариуцлага тооцох чиглэлээр Үндэсний болон дэлхий, бүс нутгийн усан спортын болон бусад эрх бүхий байгууллагуудтай үр дүнтэй харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх
  - д) Бусад спортын байгууллагуудтай авлига, ёс зүйн зөрчлийн талаар мэдээлэл солилцох,



- е) Сахилга бат, ёс зүй, бүх төрлийн хүчирхийллийн хэлбэр, хууран мэхлэлт, хууль бус бооцоо тавих, сэргээшийн асуудал болон арга хэмжээнд хөндлөнгөөс оролцох зэрэг бүхий л ёс зүйн зөрчилтэй холбоотой харилцааг зохицуулах, хянан шийдвэрлэх
- ё) Удирдах зөвлөлд жил бүр үйл ажиллагаагаа тайлагнах
- ж) Холбооны дүрмээр хүлээсэн бусад үүрэг болон Удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх
- з) Холбооны Дэлхийн сэргээшийн эсрэг байгууллага (WADA)-ын өмнө хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавих

1.5 Зөвлөлийн үйл ажиллагаа, шийдвэр гаргалт бусдаас хараат бус байх бөгөөд зөвхөн Холбооны дүрэм, Ёс зүйн дүрэм болон Зөвлөлийн журмын хүрээнд ажиллана.

### **ХОЁР. Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн зарчим**

2.1 Зөвлөл нь Холбооны дүрэм, Ёс зүйн дүрэм болон Удирдах зөвлөлөөс баталсан тогтоол шийдвэрүүдийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

2.2 Зөвлөлийн шийдвэрийг бүх гишүүдийн ердийн олонхийн саналаар гаргах бөгөөд зөвлөлийн дарга саналын давуу эрх эдлэхгүй.

2.3 Удирдах зөвлөлд оруулж шийдвэрлүүлэх аливаа асуудалд, тухайн асуудлаар цөөнх болсон гишүүдийн зарчмын зөрүүтэй байр суурийг заавал танилцуулна.

2.4 Зөвлөл нь тодорхой асуудлаар гишүүдийн дундаас ажлын хэсэг байгуулан ажиллаж болно.

2.5 Зөвлөл нь Удирдах зөвлөлөөр батлуулсан үйл ажиллагааны үндсэн журамтай байна.

2.6 Ёс зүйн зөвлөл чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллахад доорхи бүтэц нэгжүүд туслан, дэмжиж ажиллана. Үүнд:

- а) Сургалт сурталчилгааны баг (сэргээшийн эсрэг асуудлаар)
- б) ЕНБД болон шаардлагатай тохиолдолд Холбооны албан хаагчид

2.7 Ёс зүйн зөвлөл нь өөрийн ажлын байртай байж болох бөгөөд ёс зүйн зөвлөлийн гишүүдийн болон бичиг баримтын аюулгүй байдлыг сайтар хангасан байна.

2.8 Шаардлагатай тохиолдолд Ёс зүйн зөвлөл нь Холбооны нөөц боломж, албан хаагчдын үзүүлж буй үйлчилгээг ашиглаж болох бөгөөд энэ нь зөвлөлийн бие даасан, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулахад нь нөлөөлөхөөргүй байна.

2.9 Ёс зүйн зөвлөлийг чиг үүргээ хэрэгжүүлэхэд зориулан Холбооны Удирдах зөвлөл төсөв хуваарьлах, гарсан зардлыг нь нөхөн төлөх асуудлыг шийдвэрлэж болно.



### **ГУРАВ. Ёс зүйн зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн**

3.1 Зөвлөл нь Удирдах зөвлөлөөс сонгогдож томилогдсон таван (5) хүний бүрэлдэхүүнтэй байна.

3.2 Холбооны Их хурал хуралдаж, шинээр бүрэлдсэн Удирдах зөвлөл Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг шинээр томилсноор өмнөх зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болно.

3.3 Зөвлөлийн гишүүн нь доорхи шаардлагыг хангасан байна:

(а) Холбооны гишүүн бөгөөд тухайн жилийн татвараа төлсөн байх

(б) 18 нас хүрсэн

(в) Сэргээшийн болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй байх

(г) Зөвлөлийн бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 20 хувиас багагүй байна.

3.4 Зөвлөлийн бүрэлдэхүүн бүрэн ирцээр хуралдаж олонхийн санал авсан гишүүнийг Зөвлөлийн даргаар сонгоно

3.5 Ёс зүйн зөвлөлийн гишүүнийг өөрийн хүсэлтээр болон Удирдах зөвлөлийн шийдвэрээр хугацаанаас нь өмнө чөлөөлж болно.

3.6 Зөвлөлийн гишүүн үргэлжлүүлэн ажиллах боломжгүй болсон эсвэл чөлөөлөгдсөн тохиолдолд Удирдах зөвлөлөөс орны хүнийг сонгож томилно.

### **ДӨРӨВ. Ёс зүйн зөвлөлийн гишүүний эрх, үүрэг**

Зөвлөлийн гишүүн доорхи үүргийг хүлээнэ:

4.1 Холбооны болон Ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ажиллах бөгөөд үнэнч шударгаар, ёс суртахууны өндөр түвшинд үйл ажиллагаагаа явуулна

4.2 Зөвлөлийн даргын томилсноор зөрчлийн хэргийн шалгалтыг хариуцан ажиллах, Хянан шийдвэрлэх сонголд оролцох

4.3 Ёс зүйн зөрчлийг шалгах, хянан шийдвэрлэх бүхий л шатанд усан спортын ашиг сонирхлыг эрхэмлэн дээдэлж, бусдын нөлөөнд авталгүй, өөрийн бодит үнэлэлт дүгнэлтэнд суурьласан, бие даасан шийдвэрийг гаргаж оролцох

4.4 Зөвлөлийн гишүүний болон зөвлөлийн нэр хүндийг унагах, зөвлөлд итгэх итгэлийг алдагдуулах аливаа үйлдэл/ эс үйлдэл гаргахгүй байх.



4.5 Холбооны болон ёс зүйн дүрэмд заасан зарчимд нийцэхгүй үйл ажиллагаа явуулдаг байгууллага, хувь хүмүүстэй холбоо тогтоох, явуулж буй үйл ажиллагаанд нь хамрагдахгүй байх

4.6 Зөвлөлийн дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, ёс зүйн зөрчил гаргасан гишүүнийг Ёс зүйн зөвлөл болон Хяналтын зөвлөлийн саналыг үндэслэн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр хугацаанаас нь өмнө чөлөөлж болно

4.7 Зөрчлийн хэргийн шалгалт, хянан шийдвэрлэх ажиллагааны болон хувийн нууцыг чанд хадгалж, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх

4.8 Холбооны бусад зөвлөлүүдтэй нягт холбоотой ажиллаж, тэдэнд ёс зүйн дүрмийн сургалт болон арга зүйн туслалцаа үзүүлэх

#### **ТАВ. Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны дараалал**

5.1 Ёс зүйн зөвлөл нь ёс зүйн болзошгүй зөрчлийг дараахи процессийн дагуу хянан шийдвэрлэх үйл ажиллагааг явуулна.

5.2 Ёс зүйн зөрчилд тооцогдож болох аливаа үйлдэл, хандлага, хүсэлт зэрэг ёс зүйн болзошгүй зөрчлийн талаархи гомдол мэдээллийг бүртгэн хүлээж авах. Үүнд:

- Гомдол мэдээлэлд ёс зүйн дүрмийн нэг болон түүнээс олон заалтыг зөрчсөн гэх хангалттай баримт байгаа эсэх, тухайн зөрчлийг ирсэн гомдол мэдээллийн хүрээнд шийдвэрлэх боломжтой эсэх талаархи урьдчилсан дүгнэлтийг гаргах
- Ёс зүйн дүрмийн нэг болон түүнээс олон заалтыг зөрчсөн гэх хангалттай баримт байхгүй эсвэл Зөвлөлийн чиг үүрэгт хамаарахгүй гэж үзвэл шалгалтын ажиллагаа явуулахаас татгалзана
- Ёс зүйн дүрмийн болзошгүй зөрчил мөн гэж үзвэл гомдол мэдээлэл гаргагчаас шийдвэр гаргахад нь туслах нэмэлт мэдээлэл, нотлох баримтыг хүсэх
- Анхны болон нэмэлтээр ирүүлсэн нотлох баримтууд нь хангалттай байна гэж үзвэл ёс зүйн болзошгүй зөрчлийн шалгалтын ажиллагааг эхлүүлэх

5.3 Ёс зүйн болзошгүй зөрчлийн шалгалтын ажиллагааг явуулах. Үүнд:

- Хариуцагчид болзошгүй ёс зүйн зөрчил болон түүнтэй холбоотой шалгалтын ажиллагаа эхэлсэн тухай мэдэгдэж, шалгалтын ажилд зориулан бичгээр тайлбар мэдээлэл өгөх эрхээр хангана
- Тамирчидтай холбоотой асуудлыг дасгалжуулагч болон асран хамгаалагчийг байлцуулан шийдэх бөгөөд онц ноцтой биш бол тэмцээнд оролцож буй тамирчны сэтгэл зүйд нөлөөлж амжилтанд сөргөөр нөлөөлөхгүй байх зорилгоор шалгалтын ажиллагааг хойшлуулж болно.



- Ёс зүйн зөрчил нь эхний байдлаар нотлогдож байгаа хариуцагчид ёс зүйн зөрчлөө хүлээн зөвшөөрч тохирсон шийтгэлээ хүлээхийг сануулсан захидал илгээх. Хариуцагч зөрчлөө хүлээн зөвшөөрвөл зөрчилд тохирсон шийтгэлийг оногдуулах
- Зөвлөлийн дарга ёс зүйн болзошгүй зөрчлийн шалгалтын ажиллагааг явуулж, нотлох баримт бүрдүүлж, зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх сонголд танилцуулах үүрэгтэй Зөвлөлийн нэг гишүүнийг томилно
- Ёс зүйн зөвлөл нь болзошгүй ёс зүйн зөрчлийн шалгалтын ажил дуусч, шийдвэр эцэслэн гарах хүртэл хариуцагчийн аюулгүй байдал, олон нийтийн дунд усан спортын нэр хүндийг унахаас сэргийлж түр түтгэлзүүлэх арга хэмжээг авч болно.
- Зөвлөлийн гишүүн болзошгүй ёс зүйн зөрчлийг шалгаж, хэргийн нотлох баримтыг бүрдүүлэн Ёс зүйн зөвлөлийн даргад хүргүүлснээр зөрчлийн хэргийг шалгалтын ажиллагаа дуусаж хянан шийдвэрлэх явц эхэлнэ.

#### 5.4 Ёс зүйн болзошгүй зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, сонголт явуулах. Үүнд:

- Ёс зүйн зөвлөлийн гишүүнээс болзошгүй ёс зүйн зөрчлийн нотлох баримтыг хүлээн авмагц Ёс зүйн зөвлөлийн дарга нь, зөрчлийн хэргийг Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд Ёс зүйн зөвлөлийн гурван (3) гишүүнийг томилж Зөрчлийн хэргийг Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнийг томилно.
- Ёс зүйн зөвлөлийн дарга нь Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд багтсан Ёс зүйн зөвлөлийн нэг (1) гишүүнийг Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний даргаар томилох бөгөөд тухайн гишүүн Сонсголыг удирдан явуулна. Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний дарга нь бусад гишүүдийн адил саналын нэг эрхтэй байна.
- Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний дарга Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх сонсголын товыг зарлаж оролцогч бүх талуудад хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэн тухай мэдэгдлийг болзошгүй зөрчлийн хэргийн хавтаст баримтын хамт хүргүүлж, тэднийг өөрсдийн зардлаар эрх зүйн туслалцаа авах боломжоор хангана
- Хариуцагч Хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнийг эсэргүүцэж болох бөгөөд эсэргүүцлийг хүлээж авах эсэхийг Ёс зүйн зөвлөлийн дарга шийдвэрлэнэ.
- Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх сонголд талууд мэдүүлэг тайлбараа өгч дууссаны дараа хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн зөрчил гарсан эсэхийг шийдвэрлэнэ.

#### 5.5 Шийдвэрийг мэдээлэх. Үүнд:

- Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүн шийдвэрээ Холбоо, Ёс зүйн зөвлөл, хариуцагч болон түүний харьяалдаг Холбооны гишүүн байгууллага клубт илгээнэ.



- Холбоо нь өөрийн харилцаа холбооны сүвгийг ашиглан шийдвэрийг олон нийтэд мэдээлж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.

5.6 Зөвлөл нь ёс зүйн болзошгүй зөрчил нь эрүүгийн хуулийн хүрээнд шийдэгдэх ёстой гэж үзвэл асуудлыг холбогдох байгуулагуудад шилжүүлэн шийдвэрлэнэ.